

БАЯНХОНГОР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН
ДОТООД ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН НЭГЖЭЭС 2024 ОНД ХИЙСЭН
АЖЛЫН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

2024 оны 12 дугаар сарын 20

Номгон

№	Дотоод хяналт шалгалтын чиглэл	Хяналт шалгалт хийсэн ажлын биелэлт	Биелэлтийн хувь
1	Дотоод хяналт шалгалтын нэгжээс 2022, 2023 өгсөн зөвлөмжийн биелэлт	Дотоод хяналт шалгалтын нэгжээс 2022, 2023 өгсөн зөвлөмжийн биелэлтийг заасан хугацаанд биелүүлж ажилласан байна.	95 хувь
2	ТАХ-ын хувийн хэргийн иж бүрдэлд хяналт шалгалт хийх	Төрийн албан хаагчийн хувийн хэрэг хөтлөх журмын дагуу хяналт шалгалтыг хийж тус онд шинээр томилогдсон 5 албан хаагчийн хуувийн хэргийн бүрдлийг 2024 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор хангаж ажиллах чиглэл өгсөн.	100 хувь
3	Байгууллагын цахилгаан эрчим хүч ашиглалтын 2022, 2023 оны төлбөрийн байдалд шинжилгээ хийж дүгнэлт гаргах	Тооцооллоос харахад 2023 оны 2, 4, 5, 6, 10 дугаар саруудад 2024 оны мөн саруудаас 98,1-407,9 мянган төгрөг буюу 1268,7 мянган төгрөгөөр илүү, 2024 оны 1, 3, 7, 8, 9, 11 дүгээр саруудад 2023 оны мөн саруудаас 10,4-665,1 мянган төгрөг буюу 1423,7 мянган төгрөг илүү төлсөн байна. Үүнтэй холбогдуулан зөвлөмж өгч ажилласан.	100 хувь
4	Төрийн үйлчилгээний болон гэрээт алба хаагчидтай байгуулсан хөдөлмөрийн гэрээний биелэлт /2023,2024/	Архивт байгаа баримтаас үзэхэд төрийн үйлчилгээний болон гэрээт алба хаагчидтай 2023 онд 9 гэрээ, 2024 оны 5 дугаар сарын байдлаар 5 хөдөлмөрийн гэрээ байгуулан ажилласан байна. Тус гэрээтэй холбоотойгоор хүчин төгөлдөр байдалд хяналт тавьж тухай бүр албажуулан ажиллах шаардлагатай байгаа талаар илтгэх хуудсыг бичиж хүргүүлсэн.	100 хувь
5	Байгууллагын хөдөлмөрийн дотоод журам, хамтын сан, ҮЭ хорооны суутгалын уялдаа холбоонд хяналт тавих	Баянхонгор аймгийн Засаг даргын Тамгын газар, байгууллагын дэргэдэх Үйлдвэрчний эвлэлийн хорооны хооронд байгуулсан хамтын гэрээ нь 8 бүлэг 59 заалттайгаар батлагдан мөрдөгдөж байгаа бөгөөд хамтын гэрээгээр цалин хөлс, тэтгэвэр, тэтгэмж, туламж, хөнгөлөлт, ажил амралтын цаг, хөдөлмөр хамгаалал, хөдөлмөрийн нөхцөлийг сайжруулах асуудлууд бүрэн тусгагдсан байна. Цаашид албан хаагчид нь Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчийн ёс зүйн дүрмийг чанд мөрдөж ажлын цагаа баримтлан, хувцаслалтын стандартыг мөрдөж ажиллах талаар санал хүргүүлэн ажилласан.	100 хувь

ХЯНАСАН
ДОТООД ХЯНАЛТЫН ЗӨВЛӨЛИЙН
ДАРГА  Л.МАНДАЛ

БИЕЛЭЛТ НЭГТГЭСЭН
ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙН ХЭЛТСИЙН
МЭРГЭЖИЛТЭН  Ж.ЛХАМДУЛАМ